



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.20, Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоолоор баталсан тус Хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дах заалтуудыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь**:

- “Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага тогтоох, үнэлэх журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.
- Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг уг журмын дагуу тайлagnаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
- Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Тусгай зөвшөөрлийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Н.Жигжидсүрэн/-т даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА
ТОГТООХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Эрчим хүчний тухай хуулийн 12.1-д заасан эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, нөхцөл шаардлагын биелэлтийг тайлагнах, үнэлэх, дүгнэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага тогтоох

2.1. Эрчим хүчний зохицуулах хороо (цаашид ЭХЗХ гэх) нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох ба уг нөхцөл, шаардлагад ерөнхий зүйл, тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ, тусгай зөвшөөрлийн нөхцөл, тусгай зөвшөөрлийн шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг гэсэн бүрдэл хэсгүүдийг заавал тусгасан байна.

2.2. Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.11-д заасан тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах нөхцлүүдийг хангасан байна.

- 2.2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрдүүлсэн байх;
- 2.2.2. Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах дадлага, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх;
- 2.2.3. Үйлдвэрлэсэн, түгээсэн, хангасан эрчим хүчийг хэмжих баталгаажсан тоолуур, хэмжих хэрэгсэлтэй байх;
- 2.2.4. Техникийн алдагдал, горим тооцоо, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний программ хангамжууд, тайлагналын системтэй байх;
- 2.2.5. Технологийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаарддагдах багаж хэрэгсэл, машин механизмтай байх;
- 2.2.6. Гарч болзошгүй аваарь, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүйн нөөцтэй байх;
- 2.2.7. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй байх, тэдгээрийг хугацаанд нь хэрэгжүүлэх;
- 2.2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байх;

2.3. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгай зөвшөөрлийн төрөл бүрээр нэгдүгээр хавсралтын дагуу тогтоох ба үйл ажиллагааны шаардлагыг хангаж ажилласан байдалд жил бүр дүгнэлт өгч, тусгай

зөвшөөрлийн шаардлагын хүрээнд мөрдөж ажиллах зорилтыг жил бүр шинэчлэн тогтооно.

2.4. Тухайн онд мөрдөж ажиллах зорилтыг тогтоохдоо энэхүү журмын 3.1, 3.2 дахь заалтуудын хүрээнд хийгдсэн явцын хяналтын тайлан, үйл ажиллагааны доголдож байгаа үзүүлэлтүүдэд үндэслэн тогтооно.

2.5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд тухайн онд мөрдөж ажиллах зорилтын саналыг мэргэжилтэн боловсруулж, Хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулна.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн оны зорилтот үзүүлэлтүүд нийт 100 оноогоор дүгнэгдэх ба үзүүлэлт бүрд харгалзах оноо нь тухайн үзүүлэлтийн ач холбогдол, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран харилцан адилгүй байна.

2.7. Хорооны хурлаас баталсан зорилтот үзүүлэлтийг жил бүрийн 2 дугаар сард багтаан ЭХЗХ-ны цахим хуудсанд байрлах “Тусгай зөвшөөрлийн цахим системд” байрлуулна.

Гурав. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд хяналт тавих

3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хариуцсан мэргэжилтэн хяналт тавих ба тухайн онд тусгай зөвшөөрөл эзэмшигч компани дээр ажиллах хуваарийг гаргаж батлуулсан байна.

3.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт, мониторинг хийж, дүгнэлт гаргана.

- 3.2.1 Тусгай зөвшөөрлийн нөхцлүүд хангагдаж байгаа эсэх;
- 3.2.2 Тусгай зөвшөөрлийн шаардлагын тухайн оны зорилтын хүрээнд төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилт;
- 3.2.3 Нөхцөл, шаардлагад тогтоосон үзүүлэлтүүдийн хүрээнд цаашид хэрэгжүүлэх, шаардлагатай ажлууд;

3.3 Энэхүү журмын 3.1, 3.2-т заасан нөхцлөөс гадна ЭХЗХ-ны удирдамжаар болон хэрэглэгч, иргэн, бусад хуулийн этгээдийн гаргасан санал, гомдол, хүсэлтийн дагуу хяналт, шалгалт хийгдэж болно.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тайлagnах, үнэлэх

4.1. Энэхүү журмын 2.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр өөрт олгогдсон тусгай зөвшөөрлийн нэр төрөл бүрээр тайлagnана.

4.2. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч хагас жил тутамд, бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид дараа жилийн 2 дугаар сарын 20-ны дотор цахим байдлаар тайлagnана.

4.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тайланг “Тусгай зөвшөөрлийн цахим систем”-д хандаж хоёрдугаар хавсралтад үзүүлсэн загварын дагуу тайлагнана. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны техник, эдийн засаг, санхүүгийн байдалд үнэлгээ өгөхөд шаардлагатай судалгаа, мэдээллийг ЭХЗХ-ны шаардсанаар цаг тухайд нь үнэн зөвөөр гаргаж өгнө.

4.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтийг хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу үнэлж, “Тусгай зөвшөөрлийн цахим систем”-д мэдээлнэ.

4.5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг тухайн оны тогтоосон зорилт, үзүүлэлтүүдийн биелэлтэд өгсөн онооны нийлбэрээр дараах байдлаар дүгнэнэ.

№	Нөхцөл шаардлагын биелэлт /хувиар/	Үнэлгээ
1	96-100	Хангалттай
2	75-96 хүртэл	Сайн
3	60-75 хүртэл	Дунд
4	60-аас доош	Хангалтгүй

4.6 Эрчим хүчний үйл ажиллагааг бусад үйл ажиллагаатай хавсран эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд зөвхөн эрчим хүчний үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг дүгнэнэ.

--- оОо ---

Тусгай зөвшөөрлийн нөхцөл,
шаардлага тогтоох, үнэлэх журмын
нэгдүгээр хавсралт

Тусгай зөвшөөрлийн шаардлага

1. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт
1	Эрчим хүчний барилга байгууламжийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд барьж байгуулан, ашиглалтад оруулах;
2	“Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм” /БНБД 11-01-98/ болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу барилга байгууламжийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх, батлуулах;
3	“Зураг төсөл, хайгуул, судалгааны ажилд улсын экспертиз хийх дүрэм” /БНБД 11-203-04/-ийн дагуу барилга байгууламжийн зураг төсөлд улсын экспертиз хийлгэх;
4	Тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 24 сарын дотор барилга байгууламжийг заасан хугацаанд барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх талаар хөрөнгө оруулагчтай эцэслэн тохиролцож гэрээ хэлцэл байгуулсан байх;
5	Барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах нөхцөл биелэгдсэнээс хойш 12 сарын дотор эхлүүлсэн байх;
6	Барилга байгууламжийн барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт тавих, барилга угсралтын ил, далд ажлын акт, бичиг баримтыг баталгаажуулах;
7	“Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм” /БНБД 11-04-99/-ийг мөрдөж ажиллах, мэргэжлийн хяналтын болон зөвлөх эрх бүхий байгууллагаас барилга байгууламжийн барилга угсралтын ажилд хийсэн үзлэг, шалгалтын үр дүнд өгсөн сануулга, анхааруулга, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах;
8	Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, зүгшрүүлэлтийг хийж найдвартай ажиллагааг хангах, барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас өмнө түүнийг 72 цагаас багагүй хугацаанд хэвийн болон хоосон явалтын горимоор ажиллуулж турших, илэрсэн алдаа, дутагдлыг арилгах;
	Дүн

2. Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан эрчим хүч үйлдвэрлэх;	
2	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;	
3	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн технологийн процессыг холбогдох норм, стандартын дагуу аюулгүй явуулж, осол зөрчилгүй ажиллах;	

4	Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;	
5	Үйлдвэрлэлийн барилга болон далангийн ашиглалт, аюулгүй байдал, усан сангийн ашиглалт, хамгаалалт, усны түвшин, голын урсац зэргийг багтаасан хяналт-шинжилгээний төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж, холбогдох байгууллагаар батлуулах (УЦС-ын хувьд);	
6	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;	
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
	Дүн	

3. Дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэх;	
2	Дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;	
3	Дулааны үйлдвэрлэлийн технологийн процессыг холбогдох норм, стандартын дагуу аюулгүй явуулж, осол зөрчилгүй ажиллах;	
4	Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;	
5	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;	
6	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
	Дүн	

4. Цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол зөрчилгүй ажиллах;	
2	Цахилгаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
3	Цахилгаан дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
4	Цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон түгээх сүлжээ болон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаанаар хангах;	

5	Цахилгаан дамжуулах сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг нэмэгдүүлэхгүй, зохистой түвшинд байлгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	
6	Цахилгаан дамжуулах сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
7	Цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран хангах;	
8	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

5. Дулаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол зөрчилгүй ажиллах;	
2	Дулаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
3	Дулаан дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
4	Дулаан дамжуулах сүлжээнд холбогдсон түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан дулаанаар хангах;	
5	Дулаан дамжуулах сүлжээний нэгж усны зарцуулалт техникийн алдагдлыг насос станц, магистраль шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, нэгж усны зарцуулалтыг нэмэгдүүлэхгүй, зохистой түвшинд байлгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	
6	Дулаан дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг хангах, нэмэлт усны алдагдлыг бууруулах үүднээс дамжуулах сүлжээний оновчтой горим, схемийг тогтоох;	
7	Дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
8	Дулаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;	
9	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

6. Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан түгээх сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол зөрчилгүй ажиллах;	

2	Цахилгаан түгээх сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж, түгээлтийн алдагдлыг бууруулах;	
3	Цахилгаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
4	Цахилгаан түгээх сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
5	Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаанаар хангах;	
6	Цахилгаан түгээх сүлжээний найдвартай ажиллагааг хангах, техникийн алдагдлыг бууруулах үүднээс түгээх сүлжээний оновчтой горим, схемийг тогтоох, түгээх сүлжээнд гарч болох аваарь, саатал, тасралт зэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, аваарийн үед ажиллах горимыг боловсруулж мөрдөх;	
7	Цахилгаан түгээх сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
8	Цахилгаан түгээх сүлжээний хамгаалалтын зурvasын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих;	
9	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
	Дун	

7. Дулаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулаан түгээх сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол зөрчилгүй ажиллах;	
2	Дулаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
3	Дулаан түгээх сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
4	Дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг чанарын шаардлага хангасан дулаанаар хангах;	
5	Дулаан түгээх сүлжээний найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах үүднээс түгээх сүлжээний оновчтой горим, схемийг тогтоох, түгээх сүлжээнд гарч болох аваарь, саатал, тасралт зэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, аваарийн үед ажиллах горимыг боловсруулж мөрдөх;	
6	Дулаан түгээх сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
7	Дулаан түгээх сүлжээний хамгаалалтын зурvasын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих;	

8	Дулаан түгээх сүлжээний нэгж усны зарцуулалт, нэмэлт усны зарцуулалт, нэгж цахилгааны зарцуулалтыг норм дүрэм, стандартын дагуу бууруулан ажиллах;	
9	Гадна агаарын хэмээс хамааруулсан дулааны эрчим хүчний хангамж, хэрэглээний тэнцлийг сар бүрээр тооцож гаргах;	
10	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

8. Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	ЭХЗХ-ноос баталсан зах зээлийн загвар, дүрэм, журмын дагуу бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс цахилгаан худалдан авах;	
2	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд хавсралтад заасан нутаг дэвсгэрийн хэрэглэгчдийг цахилгаанаар найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний чадал, цахилгаан авах талаар цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон Диспетчериин үндэсний төвтэй тохиролцох;	
3	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдэд худалдсан цахилгааны орлогоо цахилгаан нийлүүлэгчтэй байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээнд заасан харилцах дансанд төвлөрүүлэх, худалдан авсан цахилгааны төлбөрийг уг данснаас бусад иргэн, хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр цахилгаан нийлүүлэгчид шууд төлөх;	
4	Хэрэглэгчдэд цахилгаан худалдахад урьдчилсан төлбөрт болон ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх зарчмыг мөрдөх;	
5	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээг Диспетчериин үндэсний төвд бүртгүүлж, гэрээний биелэлтийг сар бүр тэдгээртэй хамтран дүгнэх, худалдан авсан, худалдсан цахилгааны тэнцлийг хийх тоолуур хэмжүүрийн баталгаажуулалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих;	
6	Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх;	
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

9. Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Энэхүү тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг дулаанаар найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний дулаан худалдан авах талаар дулаан үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон Диспетчериин үндэсний төвтэй тохиролцох;	

2	Дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаандаа бусад иргэд, хуулийн этгээдийн эзэмшилийн шугам, тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа бол ашигласны төлбөрийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу тооцож төлөх;	
3	Хэрэглэгчдэд худалдсан дулааны төлбөрийг тэдгээртэй байгуулсан гэрээнд заасан хугацаанд бүрэн цуглуулж авах, худалдан авсан дулааны төлбөрийг дулаан худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;	
4	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчтэй байгуулсан дулаан худалдах, худалдан авах гэрээний биелэлтийг улирал бүр тэдгээртэй хамтран дүгнэх, худалдан авсан, худалдсан дулааны тэнцлийг хийх тоолуур хэмжүүрийн баталгаажуулалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих;	
5	Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх;	
6	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, дулааны эрчим хүч худалдагч, хэрэглэгч талуудын эрх, үүрэг, хоорондын гэрээний талаар болон эрчим хүчийг үр ашигтай, зүй зохистой хэрэглэх талаар олон нийтэд тогтмол мэдээлэх, сурталчлах;	
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
	Дүн	

10. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан импортлох, экспортлох сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол зөрчилгүй ажиллах;	
2	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг тогтмол авах, алдагдлыг бууруулах тооцоо, судалгаа, төлөвлөгөөтэй ажилласнаар импортын алдагдлыг бууруулах;	
3	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
4	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
5	Тусгай зөвшөөрөлд заасан үйлчлэх хүрээний хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн цахилгаанаар хангах	
6	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
7	Цахилгаан импортлох, экспортлох шугамын хамгаалалтын зурvasын хэвийн байдлыг тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран хангах;	

8	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЭХЗХ, Диспетчерийн үндэсний төвөөс цахилгаан импортлох нөхцөл, болзлын талаар өгсөн удирдамж, чиглэлийн дагуу цахилгаан импортлох, экспортлох гэрээ байгуулах, хэрэгжүүлэх;	
9	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээнд цахилгаан импортлох, түүнчлэн цахилгаан импортлох хугацаа, хуваарь, техникийн нөхцлийг Диспетчерийн үндэсний төвтэй тохиролцох;	
10	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

11. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр найдвартай хангахад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гэрээ байгуулж, хамгийн бага өртийн шалгуурт нийцүүлэн шуурхай зохицуулах;	
2	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлж, хангамж, хэрэглээний дунд болон урт хугацааны төлөвлөлтийг хийх;	
3	Нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангах үүднээс цахилгаан дамжуулах сүлжээний горим, схемийн оновчлолыг хийх;	
4	Нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангаж цахилгаан, дулааны горим төлөвлөлтийг жилийн 2 хувиас илүүгүй хазайлт дотор төлөвлөх;	
5	Системийн аваарийн нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх, үүнтэй холбоотой ТЗЭ-ийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх;	
6	Импортын цахилгаан эрчим хүчний төлөвлөлтөд дүн, шинжилгээ хийж ажиллах;	
7	Бусад орны диспетчерийн байгууллагуудтай харилцах шуурхай ажиллагаа, техникийн нөхцлүүдийг тусгасан заавар боловсруулж мөрдөх, зэрэгцээ ажиллагааны үед системийн аваар эсэргүүцэх автоматик болон реле хамгаалалтын горимыг зохицуулах;	
8	Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжктэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахилгаан, дулааны хангамжийг таслах, хязгаарлах, сэргээх төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх;	
9	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

----оОо----

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага тогтоох, үнэлэх журмын хөрөнгөөдүүсээр хавсралт

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг үнэлэх загвар

№	Тусгай зөвшөөрлийн шаардлага	Тухайн оны зорилт	Биелэлт	Авах боломжтой дээд оноо	Авсан оноо УХА0315-9128808	Биелэлт хувь
1	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан эрчим хүч үйлдвэрлэх;	Үндсэн тоноглолын зогсолт (зуух-74 удаа, турбин-60 удаа)-ыг хэтрүүлэхгүй ажиллах		20		
2	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;	ДХЦЭХ-12%, ЖТХЗ цахилгаан-305.9 гр/кВтц, дулаан-174.52 кг/Гкал өртөг-45.49 төг/кВтц, 12000 төг/Гкал		40		
3	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн технологийн процессыг холбогдох норм, стандартын дагуу аюулгүй явуулж, осол зөрчилгүй ажиллах	Осол, аваари гаргахгүй ажиллах		10		
4	Эрчим хүчиний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартыар тогтоосон хэмжээнд байлгах;	MNS 6342:2012 стандартыг мөрдөх		10		
5	Үйлдвэрлэлийн барилга болон далангийн ашиглалт, аюулгүй байдал, усан сангийн ашиглалт, хамгаалалт, усны түвшин, голын урсац зэргийг багтаасан хяналт-шинжилгээний төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж, холбогдох байгууллагаар батлуулах (ҮЦС-ын хувьд);					
6	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн орлого, зардлыг тайлагнах		5		
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	Баталсан БОШХ 172 тэрбум төгрөг (2014-7 сард баталсан)		15		
	Дүн			100		



ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Тусгай зөвшөөрлийн хавсралтаар тогтоосон энэхүү нөхцөл, шаардлага нь Эрчим хүчний зохицуулах хорооны 201... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор баталсан ... дугаар тусгай зөвшөөрлийн салшгүй хэсэг болно.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хууль болон холбогдох дүрэм, журам, хууль тогтоомж болон энэхүү тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, ЭХЗХ-ны тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд хавсралтад заасан хүчин чадал бүхий үндсэн тоноглолын хүрээнд цахилгаан үйлдвэрлэх үйл ажиллагааг явуулна.

Гурав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл

3.1. Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.11-д заасан тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах нөхцлүүдийг хангасан байна.

- 3.1.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрдүүлсэн байх;
- 3.1.2. Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах дадлага, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх;
- 3.1.3. Үйлдвэрлэсэн, түгээсэн, хангасан эрчим хүчийг хэмжих баталгаажсан тоолуур, хэмжих хэрэгсэлтэй байх;
- 3.1.4. Техникийн алдагдал, горим тооцоо, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний программ хангамжууд, тайлагналын системтэй байх;
- 3.1.5. Технологийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах багаж хэрэгсэл, машин механизмтай байх;
- 3.1.6. Гарч болзошгүй аваарь, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүйн нөөцтэй байх;
- 3.1.7. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй байх, тэдгээрийг хугацаанд нь хэрэгжүүлэх;
- 3.1.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байх;

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн шаардлага

- 4.1. Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан эрчим хүч үйлдвэрлэх;
- 4.2. Цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;
- 4.3. Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн технологийн процессыг холбогдох норм, стандартын дагуу аюулгүй явуулж, осол зөрчилгүй ажиллах;
- 4.4. Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;
- 4.5. Үйлдвэрлэлийн барилга болон далангийн ашиглалт, аюулгүй байдал, усан сангийн ашиглалт, хамгаалалт, усны түвшин, голын урсац зэргийг багтаасан хяналт-шинжилгээний төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж, холбогдох байгууллагаар батлуулах (УЦС-ын хувьд);
- 4.6. Тусгай зөвшөөрөл заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;
- 4.7. ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;

Тав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

- 5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан үүргүүдийг биелүүлж ажиллана.
- 5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хавсралтаар олгосон нийт нөхцөл, шаардлагыг чанд мөрдөж, биелэлтийг тогтоосон хугацаанд үнэн зөв тайлагнах үүрэгтэй.
- 5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийлэх, нэгдэх, хуваагдах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг явуулахад шаардлагатай барилга байгууламж, бусад эд хөрөнгийг өмчлөх эрхээ шилжүүлэх, барьцаалах бол ЭХЗХ-нд 30 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэр, хаяг, дансны дугаар, байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулбал энэ тухайгаа өөрчлөлт оруулснаас хойш ажлын 5 хоногийн дотор ЭХЗХ-нд мэдэгдэнэ.

----оОо----

.... тусгай зөвшөөрлийн
нөхцөл, шаардлагын хавсралт

ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭХ ҮНДСЭН ТОНОГЛОЛ

Тоноглолын нэр, дугаар	Төрөл, маяг, заводын дугаар	Хэвийн хүч чадал	УХА03150422992 Ажиллаж эхэлсэн он, сар
Зуух №1	БКЗ-420-140 №1513	420 т/ц, 140 кГ/см2	1983.08.30
Зуух №2	БКЗ-420-140 №1558	420 т/ц, 140 кГ/см2	1984.01.16
Зуух №3	БКЗ-420-140 №1644	420 т/ц, 140 кГ/см2	1984.12.09
Зуух №4	БКЗ-420-140 №1722	420 т/ц, 140 кГ/см2	1989.12.25
Зуух №5	БКЗ-420-140 №1804	420 т/ц, 140 кГ/см2	1986.12.30
Зуух №6	БКЗ-420-140 №1872	420 т/ц, 140 кГ/см2	1987.10.31
Зуух №7	БКЗ-420-140 №1978	420 т/ц, 140 кГ/см2	1990.02.07
Зуух №8	БКЗ-420-140 №2079	420 т/ц, 140 кГ/см2	1991.12.14
Турбогенератор №1	ПТ-80/100-130-13 №1652	80 МВт	1983.10.18
Турбогенератор №2	ТГ-100/120-130-4 №26682	100 МВт	1984.11.26
Турбогенератор №3	ТГ-100/120-130-4 №26693	100 МВт	1985.12.27
Турбогенератор №4	ТГ-100/120-130-4 №26003	100 МВт	1986.12.27
Турбогенератор №5	ПТ-80/100-130-13 №2020	80 МВт	1990.01.30
Турбогенератор №6	ПТ-80/100-130-13 №2021	80 МВт	1991.12.20

----оо----